



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/190/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

“Си Пи Ти Эй Аудит” ХХК-ийн захирал: Ч.Энхчимэг
Утас: 99046494 Цахим хаяг: enkhchimeg@cptaaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: М.Мөнхтөгс
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/202
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.АЛТАНТУЯА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 2,583.4 мянган төгрөгийн үнэлгээ бүхий хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 520.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 10,393.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэг нь Хөвсгөл аймгийн Боловсролын газрын даргаар батлуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 97.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>312,332,195.25</u>	<u>251,896,276.01</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	107,104,219.65	29,778,597.08
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	107,104,219.65	29,778,597.08
3121	Төгрөг	107,104,219.65	29,778,597.08
31211	Төрийн сангийн харилцах	107,104,219.65	29,778,597.08
35	БАРАА МАТЕРИАЛ	205,227,975.60	222,117,678.93
351	Түүхий эд материал	6,069,800.00	6,071,400.00
35130	Эм боох материал	6,069,800.00	6,071,400.00
354	Хангамжийн материал	199,158,175.60	216,046,278.93
35410	Бичиг хэргийн материал	5,496,036.00	6,218,746.00
35420	Аж ахуйн материал	42,994,269.50	43,836,080.50
35440	Түлш, шатах тослох материал	20,785,000.50	56,042,037.53
35450	Барилгын засварын материал	10,686,070.00	13,886,090.00
35460	Хүнсний материал	8,418,887.00	7,366,667.30
35470	Бусад хангамжийн материал	110,777,912.60	88,696,657.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>673,101,957.14</u>	<u>669,672,265.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	673,101,957.14	669,672,265.17
392	Биет хөрөнгө	658,721,557.14	655,291,865.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	639,024,700.00	639,024,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-82,048,689.44	-92,969,787.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,971,157.08	103,233,610.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,012,915.67	-55,962,295.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,051,663.30	62,023,466.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,737,502.47	-20,186,907.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,309,360.00	60,181,266.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-41,900,899.36	-43,116,871.08
39217	Ном	3,064,683.70	3,064,683.70
393	Биет бус хөрөнгө	14,380,400.00	14,380,400.00
39301	Програм хангамж	1,012,000.00	1,012,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,012,000.00	-1,012,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,479,400.00	14,479,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-99,000.00	-99,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>985,434,152.39</u>	<u>921,568,541.18</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>985,434,152.39</u>	<u>921,568,541.18</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	985,434,152.39	921,568,541.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	168,390,133.00	168,390,133.00
51101	Өмч: - төрийн	168,390,133.00	168,390,133.00
512	Хуримтлагдсан үр дүн	800,521,919.39	736,656,308.18
51210	Өмнөх үеийн үр дүн	800,521,919.39	800,521,919.39

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-63,865,611.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,522,100.00	16,522,100.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	985,434,152.39	921,568,541.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,010,433,645.00	1,087,787,905.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,909,845.00	5,918,805.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,909,845.00	5,918,805.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,583,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	2,583,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	00.00	3,335,405.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	990,523,800.00	1,081,869,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	940,023,800.00	1,002,369,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	940,023,800.00	1,002,369,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,500,000.00	79,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,500,000.00	79,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	962,936,858.13	1,149,055,563.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	962,936,858.13	1,149,055,563.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937,134,519.67	1,149,054,073.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,463,714.69	867,609,145.27
210101	Үндсэн цалин	475,413,944.29	541,918,918.68
210102	Нэмэгдэл	212,929,402.40	273,944,995.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	27,695,000.00
210104	Урамшуулал	20,120,368.00	24,050,231.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,549,300.00	102,998,400.00
210201	Тэтгэврийн даатгал	59,822,500.00	70,044,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,754,900.00	8,240,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,662,000.00	4,121,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,662,000.00	4,121,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,647,900.00	16,469,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,332,661.54	33,696,008.22
210301	Гэрэл, цахилгаан	5,697,661.54	8,998,510.25
210302	Түлш, халаалт	3,135,000.00	22,697,497.97
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,394,532.00	6,203,419.00
210401	Бичиг хэрэг	6,342,931.00	3,313,080.00
210402	Тээвэр, шатахуун	5,127,501.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,924,100.00	2,890,339.00

**Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2105	Нормативт зардал	75,840,130.60	83,195,682.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	480,733.00	582,200.00
210502	Хоол, хүнс	75,359,397.60	82,613,482.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,660,850.00	9,709,780.00
210604	Урсгал засвар	9,660,850.00	9,709,780.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	495,000.00	799,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	799,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,398,330.84	44,842,238.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,996,900.00	5,331,815.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	232,835.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,401,430.84	39,277,588.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,802,338.46	1,489.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,802,338.46	1,489.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,802,338.46	1,489.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>47,496,786.87</u>	<u>-61,267,658.20</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,597,953.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,597,953.01
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,597,953.01
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>47,496,786.87</u>	<u>-63,865,611.21</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн <i>/Төгрөгөөр/</i>
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	615,017,857.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	615,017,857.86
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,680,140.13
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	800,521,919.39
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	800,521,919.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	800,521,919.39
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-63,865,611.21
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	736,656,308.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл <i>/Төгрөгөөр/</i>
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>990,523,800.00</u>	<u>1,081,869,100.00</u>

**Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	990,523,800.00	1,081,869,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	940,023,800.00	1,002,369,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	940,023,800.00	1,002,369,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,500,000.00	79,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,500,000.00	79,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	969,659,131.01	1,158,958,222.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	969,659,131.01	1,158,958,222.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	943,856,792.55	1,158,956,732.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,356,227.41	867,609,145.27
210101	Үндсэн цалин	475,306,457.01	541,918,918.68
210102	Нэмэгдэл	212,929,402.40	273,944,995.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	27,695,000.00
210104	Урамшуулал	20,120,368.00	24,050,231.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,549,300.00	102,998,400.00
210201	Тэтгэврийн даатгал	62,253,500.00	70,044,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,323,900.00	8,240,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,662,000.00	4,121,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,662,000.00	4,121,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,647,900.00	16,469,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,697,661.54	63,998,510.25
210301	Гэрэл, цахилгаан	5,697,661.54	8,998,510.25
210302	Түлш, халаалт	7,500,000.00	53,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	69,097,598.60	81,561,262.30
210502	Хоол, хүнс	69,097,598.60	81,561,262.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,660,850.00	15,500,000.00
210604	Урсгал засвар	9,660,850.00	15,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	495,000.00	4,010,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	4,010,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,000,155.00	23,278,815.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,933,855.00	16,416,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,066,300.00	6,861,965.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,802,338.46	1,489.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,802,338.46	1,489.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,802,338.46	1,489.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,864,668.99	-77,089,122.57
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	180,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	180,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	180,000.00

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	180,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-180,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,864,668.99	-77,269,122.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	92,465,845.66	107,104,219.65
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	107,104,219.65	29,778,597.08

2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,108,914,600.00	1,002,369,100.00	9,886,600.00	99.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,012,255,700.00	1,002,369,100.00	9,886,600.00	99.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,012,255,700.00	1,002,369,100.00	9,886,600.00	99.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	96,658,900.00	77,269,122.57	19,389,777.43	79.9
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	96,658,900.00	77,269,122.57	19,389,777.43	79.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,108,914,600.00	1,079,638,222.57	29,276,377.43	-97.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,914,600.00	1,079,638,222.57	29,276,377.43	97.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,914,600.00	1,079,638,222.57	29,276,377.43	97.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	880,391,400.00	867,609,145.27	12,782,254.73	98.5
210101	Үндсэн цалин	561,823,400.00	541,918,918.68	19,904,481.32	96.5
210102	Нэмэгдэл	299,912,200.00	273,944,995.23	25,967,204.77	91.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	27,695,000.00	-27,695,000.00	
210104	Урамшуулал	18,655,800.00	24,050,231.36	-5,394,431.36	128.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,538,300.00	102,998,400.00	6,539,900.00	94.0
210201	Тэтгэврийн даатгал	74,322,600.00	70,044,800.00	4,277,800.00	94.2
210202	Тэтгэмжийн даатгал	8,803,900.00	8,240,800.00	563,100.00	93.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,402,000.00	4,121,900.00	280,100.00	93.6
210204	Ажилгүйдлийн даатгал	4,402,000.00	4,121,900.00	280,100.00	93.6
210205	Эрүүл мэндийн даатгал	17,607,800.00	16,469,000.00	1,138,800.00	93.5
2105	Нормативт зардал	85,388,500.00	81,561,262.30	3,827,237.70	95.5

**Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	85,388,500.00	81,561,262.30	3,827,237.70	95.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,010,600.00	4,010,600.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,010,600.00	4,010,600.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29585800.00	23458815.00	6,126,985.00	79.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,723,600.00	16,596,850.00	6,126,750.00	73.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,862,200.00	6,861,965.00	235.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	107,104,219.65	-107,104,219.65	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	29,778,597.08	-29,778,597.08	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	79,500,000.00	79,498,510.25	1,489.75	100.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,500,000.00	79,498,510.25	1,489.75	100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,500,000.00	79,498,510.25	1,489.75	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,000,000.00	63,998,510.25	1,489.75	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.00	8,998,510.25	1,489.75	100.0
210302	Түлш, халаалт	53,000,000.00	53,000,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,500,000.00	15,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	15,500,000.00	15,500,000.00	0.00	100.0

3. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитын залруулга

Аудитаар шинээр орлогод авсан үндсэн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт заасан ашиглалтын хугацаанд нийцүүлэн элэгдэл тооцох жилийг зөв мөрдөөгүй 35,682.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Аудитаар 520.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 10,393.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 1 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Төлбөрийн акт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал Нийгмийн даатгалын 8 дугаар сарын тайланд 1 ажилтны цалинг 2,166.5 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, 520,0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн болон зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

3.3 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Үнэ төлбөргүй хүлээн авсан 3,210.9 мянган төгрөгийн бараа материалыг Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх орлого” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлага:

Хүүхдүүдийн эцэг эхээс авсан сургалтын хэрэглэгдэхүүний орлогыг авч, бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Илрүүлэлт:

Жилийн эцсийн Бараа материалын тооллогоор, 7,182.3 мянган төгрөгийн бараа материалын бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт хийгээгүй, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2. “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалттай нийцэхгүй ба “Бодитой оршин байх ба тохиолдсон байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлага:

Бараа материалын бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт хийгээгүй, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

1. Шатахуун зарцуулалтыг жолоочийн замын хуудас бөглүүлж, хянаж, баталгаажуулаагүй, анхны шатны баримт бүрдүүлээгүй зөрчил илэрсэн. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын “Өмчийн бүх

хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар” 4.Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана гэсэн заалт болон “*нийцсэн болон зохистой байх*” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жолоочийн замын хуудас бөглүүлж, шатахууны зарцуулалтыг хянаж, ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын www.Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдэл тооцох хугацааг алдаатай бүртгэсэн	1	35,682.4					1	35,682.4		
ДҮН	1	35,682.4					1	35,682.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал		
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		Тоо	Дүн
1	Жилийн эцсийн бараа материалын тооллого, бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт хийгээгүй	1	7,182.3			1	7,182.3							
2	Жолоочийн тооцооны замын хуудас бөглөөгүй	1	0.0							1	0.0			
3	Нийгмийн даатгалын 8-р сарын тайланд 1 ажилтны цалинг илүү тайлагнаж, илүү зардал байгууллагаас гаргасан	1	520.0	1	520.0									
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй,	1	3,210.9			1	3,210.9							
	Дүн	4	10,913.2	1	520.0	2	10,393.2	1	0.0					

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								